

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Цэцэрлэгийн зориулалтын 2033,5 мкв талбай бүхий газрыг Чингэлтэй дүүргийн Боловсролын хэлтэст шилжүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн 2016 оны А/869 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь хэсгийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших эрх шилжүүлэн авсан аж ахуйн нэгжтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн авч, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газрын албанд даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Ж.Лхагвасүрэн/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ